

“ҮНЭТ ДУРСГАЛТ ЗҮЙЛИЙН ЗЭРЭГЛЭЛД НЭР ДЭВШҮҮЛЭХ” ҮЗМЭРИЙН ЖАГСААЛТЫН ТӨСӨЛ

МОНГОЛЫН УРАН ЗУРГИЙН ГАЛЕРЕЙ								
Д/д	Үзмэрийн нэр	Хувийн дугаар	Тоо ширхэг	Хэмжээ	УБМС-ийн дугаар РСН (прораммын)	Судлагдсан сурталчлагдсан байдал	Саналын үндэслэл	СӨҮТ-ийн санал
1	Орхоны хавар	62.60	1	Өндөр-117 см Урт-162 см	1119УЗГ00304	Япон болон Катар улсад зохион байгуулагдсан олон улсын үзэсгэлэнд дэглэгдэж Монголчуудын уламжлалт ахуй, соёл, өв уламжлалыг уг бүтээлээр дамжуулан сурталчилсан. МУЗГ-“Соцреализм Монголын дүрслэх урлагт” ном 175 тал МУЗГ-“ХХ зууны Монголын шилдэг уран зураг” ном 90,91 тал	Эх орон, ард түмнээ магтан дуулж, үзэл сурталд уриалан дуудах ёстой соцреализмын давалгаан дунд бүтээл бүрээрээ сэтгэлгээний шинэчлэлийг хөндсөн уран бүтээлч бол Ц.Жамсран билээ. Түүний “Орхоны хавар” бүтээл цөн түрж, мөс урсах Орхон голын мандал дээр эргийн бургас, цэнхэр тэнгэрийн хамт мэлтэлзэн харагдах хаврын нэгэн агшныг реалист хэлбэрээр уран сайхны ямар ч хэтрүүлэггүй, тодорхой илэрхийлсэн нь 1960-аад оны монголын дүрслэх урлагт гарсан содон үзэгдэл байсан юм.	Дэмжсэн Зураггүй
2	Тайхар чулуу	61.71	1	Өндөр-200 см Урт-140 см	1119УЗГ00316	Франц болон Катар улсад зохион байгуулагдсан олон улсын үзэсгэлэнд дэглэгдэж Монголчуудын уламжлалт ахуй, соёл, өв уламжлалыг уг бүтээлээр дамжуулан сурталчилсан. Монцамэ агентлаг “Монголын дүрслэх урлагийн сор бүтээлүүд” цахим контент	Монголын орчин цагийн дүрслэх урлагт өнгийн хийсвэрлэлийг нэвтрүүлсэн Ардын зураач Б.Чогсомын бүтээсэн “Тайхар чулуу” Монголын хамгийн анхны модернист бүтээлүүдийн түүчээ гэдэгтэй урлаг судлаачид санал нэгддэг.	Дэмжсэн Зураггүй

3	Алтайн уулс	58.59	1	Өндөр-199,3 см Урт-393.5 см	1119УЗГ00305	МУЗГ-“ХХ зууны Монголын шилдэг уран зураг” ном 80,81 тал МУЗГ-“Соцриализм Монголын дүрслэх урлагт” ном 159 тал Монцамэ агентлаг “Монголын дүрслэх урлагийн сор бүтээлүүд” цахим контент	Монгол улсын төрийн шагналт, урлагийн гавьяат зүтгэлтэн, ардын зураач Л. Гаваа нь монголын шинэ театр киноны тайз чимэглэлийн урлагийн үндсийг тавьсан зураач юм. Энэхүү бүтээл нь Монголд уран зураг мэргэжлийн төвшинд хөгжин эхэлж байх үед бүтээгдсэн байгалийн томоохон хэмжээний бүтээл юм. Уг бүтээл нь "Монументаль" буюу сүрлэг хэлбэрт зохиомжилсон өнгө зохицол дүрслэлээрээ анхны бүрэн хэмжээний байгалийн уран зураг билээ.	Дэмжсэн Зураггүй
4	Жаахан шаргын нутаг	65.43	1	Өндөр-70 см Урт-189,6 см	1119УЗГ02938	МҮОРНТВ “Эх өв” нэвтрүүлэг МУЗГ-“Соцриализм Монголын дүрслэх урлагт” ном 180 тал МУЗГ-“ХХ зууны Монголын шилдэг уран зураг” 92,93 тал	Социалист бүтээн байгуулалтын тулгын чулуу болох соёлын хувьсгалыг малчны хотонд хүргэдэг байсан бодит түүх Ардын зураач Д.Амгалангийн уг бүтээлд хурц тодоор мөнхөрчээ. Өвөг дээдсийнхээ урлахуй ухааны уламжлалаас мэргэжлийн урлагт бүтээлчээр нэвтрүүлж, өөрийн гэсэн өвөрмөц, содон арга барилыг буй болгосон түүний бүтээлүүд өнөө ч дахин давтагдашгүй өнгө аясаараа гайхуулсаар байгаагийн тод жишээ нь түүх, нийгмийн чухал ач холбогдлыг илэрхийлсэн “Жаахан шаргын нутаг” хэмээх уран зураг юм.	Дэмжсэн Зураггүй
5	Бөхийж үзээгүй туг	72.21	1	Урт: 229 см	1119УЗГ00568	МҮОРНТВ “Эх өв” нэвтрүүлэг	Монголчуудын хагас зууны түүх соёл, үндэсний ёс заншил, ахуй амьдрал, аж байдал, бүтээн байгуулалт, хөгжил цэцэглэлт түүнчлэн уудам хээр тал, говь хангайн үзэсгэлэнт байгалийн	Дэмжсэн Зураггүй

							сонин дүр дүрслэлийг 3 метрийн урттай зэрлэг зааны соёоны үндсэн хэв шинжийг эвдэлгүйгээр ардын гар урлалаар дамжуулан ирээдүй хойч үедээ баримтжуулан үлдээсэн дахин давтагдашгүй түүх соёлын гайхамшигт өв юм.	
6	Буур	67.39	1	Өндөр-70 см Урт-81 см	1119УЗГ00539	Монцамэ агентлаг “Монголын дүрслэх урлагийн сор бүтээлүүд” цахим контент	Зураач А. Сэнгэцохио таван хошуу малыг гайхалтай өвөрмөц дүрсэлдэг зураач байв. Түүний морь, сарлаг, тэмээ сүрлэг, чимэглэлийн, хэтрүүлгийн хэллэгээрээ онцгой содон. Уг бүтээл нь Монгол зургийн уламжлалт дүрслэх хэлбэр, зохиомжийн шийдлийг өрнөдийн уран зургийн арга барилтай хослуулснаараа онцлог юм.	Дэмжсэн Зураггүй
7	Нүүдэл	67.37	1	Өндөр-52 см Урт-92,5 см	1119УЗГ00554	МУЗГ-“ХХ зууны Монголын шилдэг уран зураг” ном 24,25 тал МУЗГ-“Соцриализм Монголын дүрслэх урлагт” ном 190,191 тал	1950-иад оны дунд үеэс үндэсний уран зургаа сэргээхэд үнэтэй хувь нэмэр оруулсан зураачдын нэг Ц. Минжүүр нь “Нүүдэл” болон бусад зургаараа шинэ цагийн “монгол зураг”-ийн хөгжилд үнэтэй хувь нэмрээ оруулсан юм. Уг бүтээлд монгол зургийн задгай зохиомжинд европын уран зургийн шугаман алслалыг ашигласнаар нэг хавтгайд олон үйл явдлыг үзүүлэх арга ажиллагааг шинэчилсэн байна. Монголчуудын нүүж яваа айлыг замд нь тосч цайлах уламжлалт сайхан ёс заншлыг уг бүтээлдээ онцолжээ.	Дэмжсэн Зураггүй
НИЙТ 7 ДЭСИЙН 7 ШИРХЭГ								